

*Хөвсгөл аймаг дахь цагдаагийн газрын нохойн туслах
төлөөлөгч, цагдаагийн ахлах ахлагч А.Дашцоож*

“Цаасан хараал”

Аливаа бэл хөрөнгө хэтэрхий их бол гэмт хэргээс эх сурвалжтай.

О.Бальзак

Хүн төрөлхтөн модон дээр амьдрагч сармагчнаас үүсэлтэй. Газарт буусан ч модон шор, жад бэлтгэж амиа зогоож эхэлсэн. Модыг ноцоож гал гаргаж хөгжлийн буухиагаа эхэлсэн. Хайрам хүйтэн агуйг орхиж модон урцанд шилжсэн. Дулаан газарт амьдарч байснаа хүйтнийг модны тусламжтайгаар давж болохыг мэдээд дэлхийн зүг бүрт өсөж үржсэн. Модон урц нь модон гэр,байшин болж. Модоор алт мөнгө хайлуулж гүйлгээний анхны хэлбэр наймаа хийж эхэлсэн. Дараа нь арилжаа хийх ажлаа хөнгөвчлөхийн тулд алтыг модон зоргодос, цаасаар сольсон юм.

Гэвч цаас бүхэн ийм хүчтэй бус ажээ. У.Шекспирийн жүжгээ бичсэн, К.Ф.Гауссын Х-ийн 17 зэргийг бодсон, Леонардо Ди Сер Пиеро Да Винчийн Жокондаг зурсан, Жеймс Камероны Аватар кино зохиолоо бичсэн цаас тийм хүчтэй бус харин хүчит хараалын цаасыг даллах идтэй байж. Дэвтрийн, бичгийн, өнгийн цаас бол бүр эгэлхэн энгийн нэг илбэ шидгүй цааснууд. Хэн ч тэднийг авч, хаяж болно. Цаасыг анх бүтээгч нь зэрэг дэв нууцыг сайн цогцлоожээ. Үйлдвэрийн гоёмсог өнгө, будаг,өндөр нууцлал бүхий цаас л хүнд их хараал түгээж байна. Энэ бол мөнгө. Хийгээгүйг нь хийсэн болгож, хэлээгүйг нь хэлсэн болгож, бүтэхгүй, бүтэхэд цаг хугацаа шаардсан ажлыг цаг алдалгүй бүтээж, хэнч биш нэгнийг хэнээс ч илүү сод хүн болгож, өлмийд наалдсан шороог өндөр их шидтэй рашаан болгон түгээж байна. Биет болон биет бус эд байлаа ч цаана нь мөнгөн дүн үргэлж тооцоологдоно.

Аугаа Монгол 17-р зуунд Манжийн хамжлага, хотных нь баас цэвэрлэх адсага төдийхөн болж, 200 гаруй жилийн турш хээрийн зэрлэг чоныг гинжилсээр хуцдаг ч үгүй хотны нохой болгож байсан түүх ой тойноос арчигдах нь бүү хэл хөсөр эзэгнэгчдийн түүдгийнх нь сүүлчийн оч унтарч ч амжаагүй байхад буюу тэр хэцүү өдрүүдийг үдээд 100 жил ч болоогүй байж ахиад л цаасны хараалд идэгдээд байна. Чингэсээр үхэл, мөхлийн хаалга уруу алхаж биш мөлхөж ороод мөнхөд нойрсох, 200 жил бүү хэл 2 мянган жилдээ ч эргэж сэхэхээргүй тавилан хүлээж байж ч магад.

Авлига авагч цөөн хүний нүглийг

Амьдрахын мөртэй яваа олонхи үүрэх ёсгүй

Төрийн болон төрийн бус байгууллагуудын гаргасан авлигалд өртдөг байгууллагуудын судалгаанаас харахад тэргүүн эгнээнд явдаг байгууллагууд нь нийгмийн

бүх хэсэгт хүрч үйлчилдэг байгууллагууд байдаг. Жишээ нь: цагдаа, эмнэлэг, мэргэжлийн хяналтын байгууллага, газрын алба...г.м. Эдгээр байгууллагууд олон хүнтэй харьцдаг, олон ажиллагсадтай учраас бусад байгууллагуудаас илүү дээгүүр заларч байна. Биеэ өмөөрөхөөсөө урьтаж асуудлыг өнхрүүлэн үзэцгээе \Д.Намдаг\ .

Цагдаа нар авлигал авдаг. Энэ үг худал биш. Авлигал авсан цагдаа нэг бус. Гэвч тэд халагдсан. Тийм хүмүүст цагдаад байх сүүлчийн шалтаг ч байхгүй. Гэхдээ хэдэн цагдаа авлигал авсныхаа төлөө шалгагдаж байгаагаас болж бүх цагдаа ийм нэр зүүх ёсгүй. Цагдаагийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэн бүрийн сэтгэлд гэгээ татаж хаалгаар нь гарахгүй нь мэдээж. Хүүхэд нь, нөхөр нь, эхнэр нь... гэмт хэрэг үйлдсэн гэдэгтэй эвлэрч, хэдэн жилээр амьдын хагацал болохыг хэн л хүсэхэв. Тийм ч учраас бухимдсан сэтгэлдээ “нөгөө талаас авлигал авч, хэргийг нэг талд нь шийдлээ” гэцгээнэ. Авлигал авдаг хүний духан дээр тэр нь бичээсгүй байдаг болохоор цагдаад шургалж чадсан ч тун уддаггүй.

Бодомж 1: хөлчүү, бийлэгжүү эр хэн нэгний амь насыг нь бүрэлгэчихээд тань дээр хэрэг нь ирлээ. Хохирогч нь асрамжийн төвийн хамаатан садан, төрөл төрөгсөд гэх хүнгүй нэгэн байна. Дуу алдам их мөнгө таньд өгч, нуур болтол уйлсаар байж бидний дунд дуу аялан алхаж явна. Дараа дахин хөлчүүрхэж таны ээжийг, үр хүүхдийг, найзыг бүр таныг ч егүүтгэхийг үгүйсгэхгүй. Эрээн цаасны хараал гэдэг хүн бүрт хүрч чаддаг сүр хүчит зүйл.

Бодомж 2: хотын цэцэрлэгүүдэд мах нийлүүлэх тендэрт та шударгаар бус авлигал өгөн байж ялж. Чанар муутай, шинжилгээнд тэнцэхгүй мах нийлүүлснээс болж Монголын ирээдүй болсон мянга мянган хүүхэд гэдэсний өвчин тусаж үхвэл. Эрээн цаасыг тэнгэрт тултал овоолсон ч хүн дахин ганц удаа өндийх бил үү ?

Бодомж 3: шөнө дунд хөл хөдөлгөөн гэх зүйл бараг байхгүй үед нэг машин зогсоож шалгатал нилээд согтуу эрхэм явж байна. Таньд сарын цалингаас чинь чамлахааргүй их мөнгө санал болгож, “найрлаж байтал ээж минь муудаад дуудагдаад явж байна” гэх яах ч аргагүй шалтаг тоочоод байвал та Монгол зан, хүн чанар гаргаж явуулчихаад харихад гэр хороололд байх танай хашааг дайрч ороод, гэрийг тань газрын хөрстэй тэгшилж гэргийг чинь өлгийтэй хүүтэй чинь хамт эрлэгт мордуулсан байхыг та үгүйсгэж чадах уу ?

Авлигаас ангид байцгаая та минь! Өнөөдөр болоогүй ч та биднээс хамааран учирч болох аюулыг бичив. Бусдаас илүүдээ биш бусдын адил цусан зүрх, махан биет эгэл хүмүүний зовнилийн мухарт сүслэх нь: Эрээн цаасны хараал холуур байг!

Авлигалд өртсөн хэн ч ялгаагүй дөрлүүлсэн үхэр адил болно. Хамарт чинь мөнгөөр шор хатгаж, дөрлөсөн эрхэм нуруун дээр чинь залрана. Түүний заасан зүгт сажилж, зогсох газар нь зогсож, айлд орвол гарч иртэл нь хүлээж амьд хөшөө болно. Түүний сайхан зан хэзээ нэг хөдөлж идэж, уухыг минь зөвшөөрөх бол гэхчилэн өөрийн бус хүний толгойгоор амьдарлаа мэдүүлнэ. Ажлынхантай чинь муудалцуулж, авааль гэргийгээс чинь салгаж,

адаг сүүлд нь гүйцэлдүүлж үл болох даалгавар өгч, хадан хясааг мөргөж замаас зайлуул гэвэл та яах вэ ? Уул мөргөвөл эрдэнэт хүн та өөрөө амь эрсдэнэ. Гэвч хамарт чинь бат сайн хатгасан шор зоолттой байдаг. Энэ үед л та авлигал авсандаа харамсана. Харамсахад оройтоогүй ээ. Хамрынхаа шорыг сэт татахад л та дахин хэзээ ч, хэнд ч дөрлүүлэхгүй эрх чөлөөтэй болно. Ингэхийн тулд та нийтийн ашиг сонирхлыг хувийн ашиг сонирхлоос илүүд үзэн авлигал, хээл хахуулиас татгалзаж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад л болно. Хүн хүндээ л цаасан хараал илгээж байна. Амьтай, амьгүй эсвэл шинжлэх ухаанаар тайлагдашгүй илбийн ертөнцөөс цаасан хараал ирэхгүй. Өгч байгаа иргэн, авч байгаа ажилтан та хоёр л энэ эрээн цаасны хараалаас биесээ хамгаална.

Иргэн таньд уриалах нь:

Авлигалгүй амьдрахын тулд авлигал өгөхгүй байцгаая

Алба хаагчдад уриалах нь:

Эрэлт байхгүй бол нийлүүлэлт байж чадахгүй

Элээж буй цаг хугацаанд эзэн нь байж

Эрээн цаасны хараал үл хүрч

Авдаг цалиндаа сэтгэл хангалуун байж

Албандаа үнэч зүтгэхийн ерөөл өргөн өндөрлье.

Зарим үгсийн тайлбар

Авлига- ёсон бусаар шунан дурлаж авсан эд зүйл

Хээл- бусдад засдаглаж хаууль болгон өгөх эд юм. /хээл хахууль/

Хахууль- өөрийн зүй бус хэргийг биелүүлэх,бүтээхийн тулд албан тугаалтанд ил, далд аргадан өгөх

Засдаглах- муу бурууг нуун далдалж засдаглах

Ном зүй

Монгол хэлний тайлбар толь - Я.Цэвэл \1966\

Бүтээхүйн зүй тогтол сайхныг бүтээх нууц – Д.Батбаяр \2013\